



“ИТГЭЛ НАЙДВАР БОЛОМЖ УЛААНБААТАР МАРАФОН- 2025” БҮХ НИЙТИЙН ГҮЙЛТИЙН УДИРДАМЖ

Нэг. Зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон олон нийтийг спорт, хөдөлгөөнөөр нэгтгэн, эв нэгдэл, тэгш хүртээмжийг нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн урам зоригийг бадрааж, итгэл найдварыг сэргээн, биеийн тамираар дамжуулан эрүүл амьдралын хэв маягийг түгээн дэлгэрүүлж, тэдний нийгмийн оролцоог дэмжих.

Хоёр. Зохион байгуулагчид

- Ерөнхийлөгчийн Тамгын Газар
- Европын Холбооноос Монгол Улсад суугаа Төлөөлөгчийн газар
- Ахиллис Монгол ОУБ НҮТББ
- Дотоод хэргийн их сургууль

Гурав. Бүх нийтийн гүйлтийн хугацаа, зохион байгуулах журам

Хэзээ хаана:

- ✓ 2025 оны 09-р сарын 20-ны Бямба гаригт ҮЦХ-ээс гараанд гарч Дүнжингаравын зам, Маршалын дугуйн зам, Их Монгол улсын гудамж, ҮЦХ гэсэн маршрутаар явагдана.

Хамрах хүрээ:

- ✓ Гүйлт сонирхогч олон нийт, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, их дээд сургуулийн оюутнууд.

Бүх нийтийн гүйлтийн бүтэц:

- ✓ Энэхүү бүх нийтийн гүйлт нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих “Итгэл Найдвар Боломж УБ марафон 2025” болон иргэд, залуу үеийг гүйлтэд уриалах “Оюутан гүйлт 2025” хэсгүүдээс бүрдэнэ.

Бүртгэл:

- ✓ “Итгэл Найдвар Боломж УБ 2025” марафонд оролцогчдыг **9-р сарын 14-ний 24:00** цаг хүртэл <https://achilles.marathon.mn/> холбоосоор, **9-р сарын 15-16-ны 09-18 цаг** хүртэл **70131777** утсаар, **9-р сарын 17-19-ний** өдрүүдэд **СТӨ-ний 1-р давхарт болох Марафоны экспод биетээр** тус тус бүртгэнэ. 2025 оны 09-р сарын 20-нд буюу марафоны өдөр бүртгэл хийхгүй.
- ✓ Гүйлтэнд хамт олон, найз нөхөд, сургууль, ангиараа оролцох сонирхолтой бол нэгдсэн журмаар бүртгүүлж энгэрийн дугаараа хүргүүлэн авах боломжтой, 99081118, 80683355 дугаараар холбогдож байгууллага хамт олны нэгдсэн бүртгэлийн мэдээлэл авна уу.
- ✓ Оюутан ангилалд оролцох оролцогчдын бүртгэлийг ДХИС хариуцах бөгөөд тухайн их дээд сургуулиудын оюутны зөвлөл, болон зохион байгуулах хорооноос гаргасан шийдвэрийн дагуу зохион байгуулна.

HOPE & POSSIBILITY MARATHON

Марафоны экспо:

- ✓ Экспо 9-р сарын 17-19-ний өдрүүдэд СТӨ-нд болно.
- ✓ Энэхүү үйл ажиллагааны үеэр гүйлтэнд оролцогчдын бүртгэлийг баталгаажуулан энгэрийн дугаар, дагалдах эд зүйлсийг олгохоос гадна, олон нийтэд тус гүйлтийн арга хэмжээг таниулах, хөгжлийн бэрхшээлийн талаар нийгэм дэх ойлголт, хүмүүсийн хандлагыг өөрчлөх, ХБ-тэй иргэдийг нийгэмшүүлэх, спортоор дамжуулан хөгжүүлэх боломжийг сурталчлах зорилготой.
- ✓ Экспоны үеэр зохион байгуулагчид, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо, мэргэжлийн байгууллагууд, тус үйл ажиллагааг ивээн тэтгэгч байгууллагуудын үйл ажиллагааг танилцуулах үзэсгэлэн, хандивын худалдаа, танилцуулах арга хэмжээ явуулна.

Эрүүл мэндийн өдөрлөг:

- ✓ Бүх нийтийн гүйлтийн үеэр Үндэсний Цэцэрлэгт хүрээлэнгийн усан оргилууртай талбайд олон нийтийг эрүүл амьдралын дадал хэвшилд уриалах өдөрлөг зохион байгуулна.
- ✓ Уг өдөрлөгт нийтийн биеийн тамирыг дэмжих болон эрүүл зөв хооллолтын мэдээлэл өгөх, фитнес, спиннинг, шугаман бүжиг, йога, гар дээр суниалт, гийр болон бусад спортын төрлийг танилцуулах, амин дэм, хандивын бүтээгдэхүүн борлуулах үйл ажиллагаанууд болно.

Гүйлтийн зохион байгуулалт:

- ✓ Гүйлтийг ҮЦХ - Дүнжингаравын зам - Маршалын дугуйн зам - ҮЦХ гэсэн маршрутаар зохион байгуулна.
- ✓ Бүх зай төрлийн уралдаанууд ҮЦХ-ээс гарч уралдааны замд байрлах эргэлтийн цэгүүдээр тойрч эргээд ҮЦХ-д барианд орно.
- ✓ 10,21,42 км-ийн гүйлтэнд оролцогчдын амжилтыг чипээр хэмжих бөгөөд нэгдсэн дүнг гарган “Hope and Possibility Ulaanbaatar” цахим хуудсанд байршуулна.
- ✓ Эргэлтийн цэг бүрт усны цэг, анхан шатны тусламж үйлчилгээний цэгүүд байрлах ба хяналтын шүүгч нар ажиллана.
- ✓ Гүйлтийн замд хөгжөөн дэмжигчид ажиллана. Маршалын дугуйн замд байрлах 21,42 км-ийн эргэлтийн цэгт гүйгчдэд зутан шөл, амин дэм, өвчин намдаах цацлага зэргээр үйлчилнэ.

Дөрөв. Бүх нийтийн гүйлтийн ангилал ба шагнал, урамшуулал

Гүйлтийн төрөл ба ангилал: Бүх нийтийн гүйлтийн арга хэмжээ нь эрэгтэй, эмэгтэй төрлөөр энгийн, пара, оюутан ангиллаар явагдана.

Д.д	Гүйлтийн төрөл, ангилал	Насны ангилал	Шагналт байр
1	Оюутан гүйлт 5км	Насны ангилалгүй, эр/эм, энгийн/ХБ	Эхний 10 байр
2	Бүтэн марафон 42,2км	18-29, 30-39, 40-49, 50-59, 60-69, 70+	Эхний 3 байр
3	Хагас марафон 21,1км	18-29, 30-39, 40-49, 50-59, 60-69, 70+	Эхний 3 байр

**HOPE &
POSSIBILITY
MARATHON**

4	Бүх нийтийн гүйлт 10км	18-29, 30-39, 40-49, 50-59, 60-69, 70+	Эхний 3 байр
5	Бүх нийтийн гүйлт 5км	Насны ангилалгүй, эр/эм	Эхний 5 байр
6	Пара 42,2км	18-29, 30-39, 40-49, 50-59, 60-69, 70+	Эхний 3 байр
7	Пара 21,1км	18-29, 30-39, 40-49, 50-59, 60-69, 70+	Эхний 3 байр
8	Пара 10км	18-29, 30-39, 40-49, 50-59, 60-69, 70+	Эхний 3 байр
9	Пара 5км	Насны ангилалгүй, эр/эм	Эхний 5 байр
10	Гар дугуй 21,1 км	Насны ангилалгүй, эр/эм	Эхний 3 байр
11	Тэргэнцэртэй 1500 м	Насны ангилалгүй, эр/эм	Эхний 3 байр

Шагнал, урамшуулал:

- ✓ 10км, 21км, 42км зайн, энгийн болон пара төрөлд оролцогч эрэгтэй, эмэгтэй эхний 3 байранд медаль, өргөмжлөл, ивээн тэтгэгчийн шагналтай.
- ✓ 5км бүх нийтийн гүйлт нь насны ангилалгүй бөгөөд эхний 5 байранд медаль, өргөмжлөл, ивээн тэтгэгчдийн шагнал олгоно.
- ✓ “Итгэл, найдвар, боломж” марафоны барианд орсон хүн бүрт финишер медаль, батламж, ивээн тэтгэгчдийн гарын бэлэг гардуулна.
- ✓ 21км болон 42км зайн оролцогч нарын бүртгэлийн хураамжинд эд зүйлсээ хийж хадгалуулах уут, марафоны цамц нэмэлт төлбөргүй багтсан болно.
- ✓ Оюутан 5км гүйлтэд оролцсон эрэгтэй, эмэгтэй эхний 10 байранд медаль батламж, ивээн тэтгэгчдийн шагналтай.

Тав. Гүйлтэнд оролцогчдын анхаарах зүйлс

- ✓ Гүйлтэд оролцогчид төлбөрөө төлж, бүртгэлээ баталгаажуулж энгэрийн дугаар авсан байна.
- ✓ Гүйгчид зөвхөн өөрийн насны ангилалд, зөвхөн нэг зай төрөлд оролцоно.
- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй оролцогчид бүртгэлийн хураамжгүй.
- ✓ Оюутан гүйлт ангилалд оролцогчид Дотоод хэргийн их сургууль болон өөрийн суралцдаг их дээд сургуулиар дамжуулан бүртгэлийн хураамж төлөхгүй 5км зайд оролцоно.
- ✓ Ахмад болон эрүүл мэндийн асуудалтай тамирчид даралт, халуунаа үзүүлж гүйлтийн өмнө эмчийн үзлэгт орсон байна.
- ✓ Тэмцээний үеэр тамирчид сахилга батыг чанд баримтлах бөгөөд зохион байгуулалтын дүрэм журмыг зөрчих, хог хаях, орчныг бохирдуулахыг хатуу хориглоно.
- ✓ Оролцогчид бие биедээ хүндэтгэлтэй хандаж, шүүгчийн шийдвэрийг баримтална. Шүүгчийн гаргасан шийдвэрийг эсэргүүцсэн, хэрүүл маргаан үүсгэсэн бол тухайн тамирчинг тэмцээнээс хасах үндэслэл болно.
- ✓ Тэмцээний цагийг нарийн баримталж аюулгүй байдлаа ханган оролцоно.
- ✓ Тухайн өдрийн цаг агаарыг харгалзан үзэж, хувцсаа тохируулан өмсөнө.



HOPE & POSSIBILITY MARATHON

- ✓ Энгэрийн дугаар бичсэн марафоны нэрийн уутанд хийсэн эд зүйлсийг Ачаа хадгалах асарт хүлээн авна. Түрийвч, гар утас, болон бусад үнэт эд зүйлсийг хадгалахгүй бөгөөд мэдэгдэлгүй өгч, алдсан тохиолдолд хохирлыг зохион байгуулагчид хариуцахгүй.

Зургаа. Хөгжийн бэрхшээлтэй оролцогчдын анхааралд

- ✓ Хөгжийн бэрхшээлтэй оролцогчид уралдааны бүх зай төрлөөс сонгон оролцох боломжтой бөгөөд зөвхөн нэг төрөлд бүртгэлийн хураамжгүй бүртгүүлэн, энгэрийн дугаар авч оролцоно.
- ✓ ХБ ангиллын оролцогчид гүйлтийн арга хэмжээний өмнө эмчийн үзлэгт орсон байна.
- ✓ Харааны бэрхшээлтэй иргэд заавал хөтөчтэй гүйх бөгөөд хэрэв өөрийн хөтөч байхгүй тохиолдолд бүртгэлээ баталгаажуулах үедээ зохион байгуулагчдад мэдэгдэж, хөтөч авах боломжтой.

Хамтран ажиллах боломжууд:

Энэхүү арга хэмжээнд байгууллага, хувь хүмүүс дараах байдлаар хамтран ажиллаж болно. Үүнд:

- Хувь хүн, найз нөхөд, хамт олноороо марафоны дугаар аван гүйлтэд оролцох,
- Марафоны үйл ажиллагаанд хандив өгөх, шагналын санд бараа бүтээгдэхүүнээ хандивлах,
- Сайн дурын ажилтнуудын багт нэгдэж хөгжөөн дэмжих, зохион байгуулалтын үйл ажиллагаанд биечлэн оролцож туслах.

Холбоо барих:

Байгууллагын хаяг: ЧД, 4-р хороо, Сүхбаатарын гудамж-8, Цэцээ гүний байр, 315 тоот

Утас: 70131777, 99044311, 99081118, 80683355

Вэбсайт: www.achillesmongolia.mn

Имэйл: info@achillesmongolia.mn

Фэйсбүүк/Инстаграм: Hope and Possibility Ulaanbaatar